

**Мэдээгүйжүүлэгч, эрчимт эмчилгээний эмчийн ахлах,
тэргүүлэх, зөвлөх эмчийн мэргэжлийн зэргийн
шалгалт өгөх шалгуур**

ММЭнН 2013 он

Нэг. Нийтлэг шалгуур:

- 1.1. Эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй байх
- 1.2. Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний мэргэжлийн үнэмлэхтэй
- 1.3. ЭМЯ ба БЯ-ны сайдын тушаалын нийтлэг шалгуурыг хангасан байх
- 1.4. ММЭнНийн үүргээ үлгэр жишээ биелүүлдэг гишүүн байх (нийгэмлэгийн ажилд оролцсон байдлыг тусгасан тайланг бичгээр өгөх)
- 1.5. Эмчлэх тусламж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн алдаа дутагдал гаргалгүй ажилласан байх – хамт олны тодорхойлолт
- 1.6. Эмчийн ёс зүйг баримтлан ажиллаж ирсэн, байгууллагын дүрэм, дотоод дэг журам зөрчөөгүй байх – байгууллагын тодорхойлолт
- 1.7. Англи хэлний зохих мэдлэгтэй, түүнийг нотлох баримтыг (үнэмлэх, гэрчилгээ, мэргэжлийн дагуу орчуулсан ном, товхимол, материал) хавсаргана
- 1.8. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх сонирхолтой, дотоод гадаадад мэргэжлийн сургалтанд хамрагдсан, гадаад хэлний зохих мэдлэгтэй, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцож, тодорхой үр дүнд хүрсэн байх

Хоёр. Тусгай шалгуур

- 2.1. ***Мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний мэргэжлээр ахлах*** зэрэг горилогч эмчид тавигдах тусгай шалгуур:
 - 2.1.1. Мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан
 - 2.1.2. Бүтээлийн жагсаалт гаргаж, мэргэжлийн сэдвээр 2-с доошгүй өгүүлэл нийтлүүлж, 5-с доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх. Дээрх өгүүлэл, илтгэлийн нийтлэгдсэн сэтгүүл, номыг хувилж баталгаажуулж хавсаргана.

- 2.1.3. Ажилласан хугацаанд биелүүсэн багц цагийн гэрчилгээний хуулбар (мэргэжлийн дагуу сургалтанд тогтмол оролцсоныг нотлох гэрчилгээнүүд)
- 2.1.4. Мэргэжлээрээ ажилласан 8-10 жилд хийсэн ажлын тайлан (нийгэмлэгийн зэргийн шалгалтын тусгай журамын маягт 1,2-р)

2.2. Мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний мэргэжлээр тэргүүлэх зэрэг горилогч эмчид тавигдах тусгай шалгуур:

- 2.2.1. Мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний эмчийн мэргэжлийн ахлах зэрэгтэй
- 2.2.2. Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 ба түүнээс дээш мэргэжлээрээ тасралтгүй ажилласан байх
- 2.2.3. Бүтээлийн жагсаалт гаргаж, мэргэжлийн сэдвээр 3-с доошгүй өгүүлэл, 10-с доошгүй илтгэл нийтлүүлж ашигтай загварын бүтээлийн гэрчилгээ 1-с дээш авсан байх (өмнөх зэрэг хамгаалснаас хойш). Дээрх өгүүлэл, илтгэлийн нийтлэгдсэн сэтгүүл, номыг хувилж баталгаажуулж хавсаргана
- 2.2.4. Шинээр суралцсан эмч мэргэжилтнийг дагалдуулан сургаж, өөрийн мэдлэг, туршлагыг эзэмшүүлсэн, нийгэмлэгээс зохиосон сургалтын ажилд идэвхтэй оролцсон байх
- 2.2.5. Ахлах зэрэг хамгаалснаас хойшхи хугацаанд биелүүсэн багц цагийн гэрчилгээний хуулбар (мэргэжлийн дагуу сургалтанд тогтмол оролцсоныг нотлох гэрчилгээнүүд)
- 2.2.6. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан (нийгэмлэгийн зэргийн шалгалтын тусгай журмын тайлангийн маягт 1,2-р)

2.3. Мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний мэргэжлээр зөвлөх зэрэг горилогч эмчид тавигдах тусгай шалгуур:

- 2.3.1. Мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний эмчийн мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй
- 2.3.2. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш 5 ба түүнээс дээш мэргэжлээрээ тасралтгүй ажилласан ба мэргэжлээрээ 20-оос дээш жил тасралтгүй ажилласан байх, одоо уг мэргэжлээрээ ажиллаж байгаа
- 2.3.3. Эмчлэх тусламж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн алдаа дутагдал гаргалгүй ажиллаж хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэл хүлээсэн байх

- 2.3.4. Мэргэжлээрээ зөвлөх, бие даан мэргэжлийн санал, дүгнэлт гаргах, сургалт явуулах түвшинд хүрсэн, өөрийгөө орлох хэмжээний шавь нарыг бэлтгэсэн байх
- 2.3.5. Бүтээлийн жагсаалт гаргах, нийтдээ 5-с доошгүй өгүүлэл, 20-с доошгүй илтгэл нийтлүүлсэн байх (өмнөх зэргээс хойш нийтлүүлсэн бүтээлийг онцолж үзнэ) оюуны өмчийн бүтээлтэй, ашигтай загварын бүтээл-2-с дээш,
- 2.3.6. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойшх хугацаанд биелүүлсэн багц цагийн гэрчилгээний хуулбар (мэргэжлийн дагуу сургалтанд тогтмол оролцсоныг нотлох гэрчилгээнүүд)
- 2.3.7. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан (нийгэмлэгийн зэргийн шалгалтын тусгай журмын маягт 1,2-р)

Гурав. Мэргэжлийн зэрэг горилох мэргэжилтний бүрдүүлэх материал

- 3.1 ММЭНН-т гаргасан Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл
- 3.2 ЭМС-ийн тушаалаар баталагдсан “Мэргэжлийн зэрэг горилогчийн маягт”
- 3.3 Мэргэжлийн зэрэг горилж буй шатлалын нийтлэг болон тусгай шалгуурыг ханган биелүүлсэнийг баталгаажуулсан баримтууд, байгууллагадаа гаргасан хүсэлт, зэрэг горилох мэргэжлийн дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан зэргийг багтаасан хүсэлтийг бичгээр гаргасныг нь байгууллагын удирдлага хамт олны хурлаар хэлэлцүүлэн, дэмжлэг авч, зөвшөөрч, тодорхойлсон байна.
- 3.4 Энэхүү хүсэлтийг нь хамт олны хурлаар хэлэлцэн дэмжиж, зөвшөөрсөн байгууллагын даргын тодорхойлолт
- 3.5 Урьд нь хамгаалсан бол мэргэжлийн зэргийн үнэмлэх
- 3.6 Мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээний эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжил эзэмшсэн, дээшлүүлсэн үнэмлэхний баталгаажуулсан хуулбар
- 3.7 Нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулах баримтууд
- 3.8 Иргэний үнэмлэхний наториатаар баталгаажуулсан хувь,
- 3.9 3х4 хэмжээний цээж зураг- 2 хувь зэрэг болно.

Тайлангийн хүснэгт

Маягт 1

Мэдээгүйжүүлгийн хэсэгт ажилласан эмч нарын тайлан

Он	Ерөнхий мэдээгүйжүүлэг				Орчны мэдээгүйжүүлэг				Жижүүр хийсэн
	Мэс засал	Эмэг-тэйчүүд	Хүүхэд	Гэмтэл	Мэс засал	Эмэг-тэйчүүд	Хүүхэд	Гэмтэл	тоо

Маягт 2

Эрчимт эмчилгээний хэсэгт ажилласан эмч нарын тайлан

Он	Нийт үзсэн өвчтөн	Эрчимт эмчилгээний тасагт үзсэн өвчтөн	Яаралтай тусламжийн хэсэгт үзсэн өвчтөн	Дуудлагаар явсан тоо

Жич: Тайлангийн үзүүлэлтүүдийг өөрсдийн ажлын онцлогт тохируулан өөрчилж болно

Боловсруулсан: Нийгэмлэгийн зохицуулагч

Ц. Оюунжав